



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2020 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 344

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад  
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Мал эмнэлгийн хүрээлэнгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 68,705,796.75 (жаран найман сая долоон зуун таван мянга долоон зуун ерэн зургаан төгрөг далан таван мөнгө) төгрөгийн балансын үнэ, 13,741,159.44 (арван гурван сая долоон зуун дөчин нэгэн мянга нэг зуун тавин есөн төгрөг дөчин дөрвөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг “Биокомбинат” улсын төсөвт үйлдвэрийн газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Хуулийн хэлтсийн дарга Л.Цэдэвсүрэн, Мал эмнэлгийн хүрээлэнгийн захирал Б.Батцэцэг, “Биокомбинат” улсын төсөвт үйлдвэрийн газрын дарга Б.Цолмон нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

000677



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2020 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн  
544 дугаар тогтоолын хавсралт

Мал эмнэлгийн хүрээлэнгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, “Биокомбинат” улсын төсөвт үйлдвэрийн газарт  
балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

| Д/д      | Хөрөнгийн нэр                                 | Ашиглалтанд<br>орсон он | Хэмжих<br>нэгж | Тоо<br>хэмжээ | Балансын үнэ<br>(төгрөг)                                                                                 | Хуримтлагдсан<br>элэгдэл (төгрөг)                                                                                | Үлдэгдэл өртөг<br>(төгрөг)                                                                                        |
|----------|-----------------------------------------------|-------------------------|----------------|---------------|----------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1        | Вакцин холигч<br>техөөрөмж-(Цөмийн<br>энерги) | 2014                    | 1              | ш             | 68,705,796.75                                                                                            | 13,741,159.44                                                                                                    | 54,964,637.31                                                                                                     |
| Нийт дүн |                                               |                         |                |               | 68,705,796.75                                                                                            | 13,741,159.44                                                                                                    | 54,964,637.31                                                                                                     |
|          |                                               |                         |                |               | (жаран найман сая<br>долоон зуун таван<br>мянга долоон зуун<br>ерэн зургаан төгрөг<br>далан таван мөнгө) | (арван гурван<br>сая долоон зуун<br>дөчин нэгэн<br>мянга нэг зуун<br>тавин есөн<br>төгрөг дөчин<br>дөрвөн мөнгө) | (тавин дөрвөн сая<br>есөн зуун жаран<br>дөрвөн мянга<br>зургаан зуун гучин<br>долоон төгрөг<br>гучин нэгэн мөнгө) |